

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн оюутны сэтгэл ханамжийн түвшин

*Отгонбаяр Д., Сонинбаяр Ж., Зол Б., Халиун Б., Лхамдулам Б.,
Дашцэрэн Б., Батжаргал Б., Энхзул Т., Баасанжав Н.
"Ач" АУИС, Анагаахын сургууль
otgonbayar.d@ach.edu.mn*

Abstract

Student's satisfaction level in curriculum implementation

*Otgonbayar D., Soninbayar J., Zol B., Khaliun B., Lkhamdulam B.,
Dashtseren B. Batjargal B., Enkhzul T., Baasanjav N.
2 "Ach" Medical University
otgonbayar.d@ach.edu.mn*

Introduction

The curriculum development is important issue, especially student's evaluations for the implementation of the curriculum. Accordingly this time we conducted this survey to determine the level of satisfaction of students, which is a key factor in implementation of curriculum at the "Ach" Medical University.

Goal

To determine student's satisfaction level in the curriculum implementation of "Ach" Medical University.

Materials and Methods

Study was conducted descriptive study design using quantitative research methodology. The Likert scale (1-5) used for the assessment of satisfaction score. Total 1105 students were included in the study. Study questionnaire included 2 groups with 17 questionnaires.

Results

Students' satisfaction level is 3.22 point on average and students gave lowest points 2.77 on the quality of classroom, school environment, training equipment and books and course materials.

Conclusions

The average satisfaction score was 3.22 above the average but the some factors including classroom capacity, study environment, training equipment and books and course materials, textbooks were below average.

Key words: curriculum, students, satisfaction, implementation, assessment

Pp. 83-87, Table 1, Figures 2, References 7

Үндэслэл

Алма-Ата хотод 1978 онд хуралдсан ДЭМБ-ын чуулган хямд өртгөөр өндөр үр дүнд хүрэх арга бол эрүүл мэндийн анхан шатны тусламж болохыг тунхаглан, урьдчилан сэргийлэх чиглэлийг анагаах ухааны сургуулийн сургалтын хөтөлбөрт түлхүү тусган, ерөнхий мэргэжлийн эмчийг бэлтгэх бодлого дэлхий нийтийн хандлага болсон.

Улс орны анагаахын сургуулиудын суралцах жил, судлах хичээл ойролцоо боловч төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага, мэргэжилтэнд тавигдах шаардлага зөрүүтэй байгаа нь дэлхийн 6 тэрбум хүнд үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээ мөн зөрүүтэй байгааг илтгэж байна хэмээн Дэлхийн анагаах ухааны боловсролын холбоо болон эрдэмтэн судлаачид дүгнэн энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Дэлхийн анагаахын боловсролд

тавигдах тулгуур шаардлага", Номхон далайн баруун эргийн бүсийн анагаахын сургуулиудын "Боловсролын чанарын баталгаа" стандарт, зөвлөмжийг боловсруулж байна. Ийнхүү олон улсын, бүс нутгийн, орон нутгийн, сургуулиудын хүрээнд анагаахын сургалтын хөтөлбөрт явцын болон төгсгөлийн үнэлгээг тогтмол хийж, үр өгөөжийг сайжруулан, онол, эмнэлзүйн шинжлэх ухааны нэгдлийг хангасан хөтөлбөрөөр сургалтыг явуулж, ерөнхий мэргэжлийн эмчийн ажлын байранд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, сургалтын агуулга, аргазүй, орчин, үнэлгээний аргазүйг цогцоор нь шийдэж, тасралтгүй хөгжүүлэхийг улс орнуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудад санал болгож байгаа нь анагаахын сургалтыг олон улсын жишигт ойртуулан хөгжүүлэх нэг үндэслэл юм.

Монгол Улсын төрөөс эрүүл мэндийн талаар

дэлхий нийтийн баримталж буй бодлого болон өөрийн орны хүн амын эрүүл мэнд, өвчлөл, эндэгдлийн байдалтай уялдуулан анагаах ухааны боловсролын төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөртөө тогтмол үнэлгээ хийж, шинэчлэн боловсронгуй болгох, сургалтын хөтөлбөрийг уян хатан, сонголттой болгон хөгжүүлэх шаардлагатай байгаа нь дэлхий болон бүс нутгийн бусад ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг анагаахын сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хөгжлийн зүй тогтлоос харагдаж байна.

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш өмчийн олон хэлбэрийн Анагаахын сургуулиуд шинээр байгуулагдан өнөөгийн нөхцөлд сургалтыг эрхлэн явуулах эрхзүйн орчин нэгэнт бүрдэж, анагаах ухааны боловсролын салбарт зах зээлийн өрсөлдөөн бодит зүйл болж эхлээд байна.

Ийм ч учраас өнөөдөр аль улсад, ямар сургууль төгсөж мэргэжил эзэмшсэнээс хамаарахгүйгээр хаана ч очиж ажиллах чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэдэг болоход анагаах ухааны сургуулиуд үндэсний, бүс нутгийн, дэлхийн түвшинд хамтран ажиллах боллоо.

Сургалтын бодлого үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж, сургалтын явцыг 5 болон 10 жилээр төлөвлөн хэрэгжүүлэх нь академик сургалт, боловсролын үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл билээ.

“Ач” Анагаах ухааны их сургууль нь 1998 оноос эхлэн төгсөлтийн өмнөх сургалтаар мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш 18 дахь хичээлийн жилтэйгээ золгож байгаа бөгөөд энэ хугацаанд 1271 хүний их эмч, 215 хүүхдийн эмч, 334 нүүр амны их эмч, 30 уламжлалт анагаахын их эмч, 167 сувилагч, нийт 2017 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт бэлтгэн нийлүүлээд байна.

Дэлхийн болон бүс нутгийн улс орнуудын боловсролын чиг хандлага ижилсэн ойртож байгаа даяаршлын үед “Ач” Анагаах Ухааны их сургуулийн хэрэгжүүлж байгаа төгсөлтийн өмнөх сургалтын 5 мэргэжлийн салбарын сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөрт оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай нотолгоонд суурилсан дүгнэлт хийж, цаашдын зорилтыг тодорхойлох зорилгоор энэхүү сэдвийг сонгон авч судалсан болно.

Зорилго

“Ач” АУИС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг судлан тогтоох

Зорилт:

1. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээг оюутны сэтгэл ханамжийн түвшинд тодорхойлох
2. Оюутны сэтгэл ханамжийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлан тогтоох
3. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн оюутны үнэлгээг харьцуулан судлах

Хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааг “Ач” АУИС-ийн Анагаахын салбарын I-VI дамжааны (n=824) оюутан, Уламжлалт анагаахын салбарын I-VI дамжааны (n=73) оюутан, Нүүр ам судлалын салбарын I-V дамжааны (n=166) оюутан, Сувилахуйн салбарын I-IV дамжааны n=(42) нийт 1105 оюутнуудаас 2 бүлэг, 17 асуулт бүхий судалгааны асуумж хуудсаар мэдээллийг цуглуулсан. Судалгааг нэгэн агшингын дискриптив загвараар тоон судалгааны аргыг ашиглан гүйцэтгэж, оюутнуудын сэтгэл ханамжийн түвшинг асуулт тус бүрт Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл оноо өгүүлэн үнэлүүлж, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлов.

Судалгааны ажлын үр дүнгийн хүснэгт, дүрслэлийг Microsoft Office-2007 иж бүрдэл, статистик боловсруулалтыг SPSS-17,0 програмуудыг ашиглан гүйцэтгэж, хувь болон дундаж утгын статистик магадлал бүхий ялгааг 95 хувийн магадлалаар баталгаажуулан дундаж үзүүлэлт нь 3-с доош гарсан үзүүлэлтүүдийг сонгож, санал нийлэхгүй буюу сэтгэл ханамжгүй байх шалтгаан нь ямар хүчин зүйлсээс хамаарч байгааг тодорхойлов.

Үр дүн

Оюутнуудын сэтгэл ханамжийг нийт 17 асуултаар тодорхойлсон ба нийт оюутнуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж нь 3.22 ба үүнээс сэтгэл ханамжийн түвшин доогуур байсан үзүүлэлтүүд нь өрөө тасалгаа, анги танхим, сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал зэрэг үзүүлэлтүүд нь сэтгэл ханамжийн түвшин дунджаас доогуур буюу <2,77 байна (Хүснэгт 1).

Table 1. To determine student's satisfaction level in the curriculum implementation

Indicator	n	mean	Std. deviation	Std. error	95% CI* Max	95% CI* Min
Course is an excellent	745	3.13	0.98	0.06	3.19	3.08
Course management	754	3.09	1.07	0.06	3.15	3.02
Linkage between classes	687	3.26	1.01	0.06	3.32	3.20
Efficiency of the lecture, seminar, laboratory were good	748	3.10	1.08	0.06	3.17	3.04
Good linkage of the theoretical and practical courses	714	3.24	0.91	0.05	3.30	3.19
Relation between contents is good	619	3.40	0.94	0.05	3.46	3.35
Good teaching methodology	670	3.26	1.04	0.06	3.32	3.20
The method of the course is appropriate	702	3.23	0.96	0.06	3.29	3.17
The evaluation of the knowledge and skills	657	3.29	1.06	0.06	3.35	3.23
Rooms and classrooms are good enough	859	2.73	1.14	0.07	2.80	2.67
The equipment to be used in training	857	2.77	1.12	0.07	2.84	2.71
There are enough of books, textbooks, manuals and materials to be used in training	936	2.76	1.15	0.07	2.83	2.69
Classroom training was good. (lecture, practice, seminar)	698	3.23	1.04	0.06	3.29	3.17
Clinical training was good	772	3.01	1.02	0.06	3.07	2.95
The course time load is convenient for the student	690	3.22	1.05	0.06	3.28	3.16
It is convenient to learn the lesson schedule	686	3.21	1.08	0.06	3.27	3.14
I can enough attend the training	607	3.50	0.98	0.06	3.55	3.44
Mean		3.22	1.04	0.06	3.28	3.16

Оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага байсан үзүүлэлт буюу өрөө тасалгаа, анги танхимын хүрэлцээ хангалтгүй байгаа гэдэгт нийт судалгаанд хамрагдсан 1105 оюутнуудын n=859 (77,7%) нь хангалтгүй үнэлгээ өгсөн ба үүнд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг судлан

үзэхэд давхардсан тоогоор өрөө, тасалгааны хүрэлцээ муу гэж хариулсан 34%, тохижилт муу гэж 18%, удирдлагаас анхаардаггүй гэж 18%, шинэчлэл хийдэггүй гэж 13%, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангахгүй гэж 12% нь үзсэн байна (Зураг 1).

**Figure 1. Rooms and classrooms are good enough – dissident (77,7%)**

Мөн сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл сайн гэдэгт $n=857$ оюутан буюу 77,5% нь санал нийлэхгүй гэж хариулсан бол санал нийлэхгүй байгаа хүчин зүйлсийг судлахад хүрэлцээ 40%, шаардлага хангахгүй 20%, хуучирсан 17%, хоцрогдсон 15%, бусад шалтгаан 6% гэж хариулсан бол сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага,

ашиглах материал хангалттай гэсэн асуултанд нийт оюутнуудын 936 буюу 84,7% нь санал нийлэхгүй байсан ба үүний 28% нь номын фонд хангалтгүй, 22% нь номын сангийн үйлчилгээ хангалтгүй, 21% нь үнэ өртөг ихтэй, 11% нь хуучирч хоцрогдсон, 12% нь ашиглах материалын хангалтгүй, 5% нь бусад шалтгаан гэж хариулсан байна (Зураг 2).



Figure 2. There are plenty of books, textbooks, manuals and materials to be used in training – dissident (84,7%)

Эмнэлзүйн сургалт сайн явагдаж байна гэдэгт нийт $n=772$ оюутан (69,8%) оюутан сэтгэл ханамж дундээрэг гэсэн үнэлгээ өгсө буюу 3.01 гэж үнэлсэн ба үүний шалтгаан нь ур чадвар хөгжүүлэх төв дутмаг гэж 23%, эмнэлгийн орчин дахь эмнэлзүйн сургалт бага гэж 22%, өвчтөн үзэх боломж байхгүй, эмнэлгүүд хүлээж авдаггүй гэж тус бүр 18%, багш эмнэлзүйд оролцдоггүй гэж 14, бусад гэж 5% нь хариулжээ. Сургалтын зохион байгуулалт сайн гэдэг асуултанд $n=754$ (68,2%) оюутансэтгэл ханамж дунд буюу 3.09 байсан бөгөөд нөлөөлж буй хүчин зүйлсүүдийг судлахад 22% нь хичээлийн хуваарь тохиромжгүй, 15% нь анги хэсэг, оюутны тоо тохиромжгүй, 20% нь хичээлийн уялдаа, дараалал таарахгүй, 18% нь хөтөлбөрийн агуулга оновчгүй, 17% нь багш, тэнхмийн үйл ажиллагаа хангалтгүй, 7% нь бусад шалтгаан гэж хариулсан байна.

Салбаруудыг харьцуулан судлахад Анагаахын салбар, Уламжлалт АУ-ны салбар өрөө тасалгаа, анги танхим, сургалтанд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтанд хэрэглэгдэх ном сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай гэдэгт санал нийлэхгүй буюу <2,8 гэсэн бол НАС-ын салбар эдгээр асуултуудаас гадна сургалт нь үр дүнтэй сайн сургалт, сургалтын зохион байгуулалт, лекц, дадлага, семинар, лаборатори, бие

даалтын хичээлийн үр өгөөж сайн, оюутны сургалтын ачаалал тохиромжтой гэдэгт санал нийлэхгүй буюу сэтгэл ханамжийн түвшин 2,6-3.0 байна($p=0.5$). Харин Сувилахуйн салбар лекц, дадлага, семинар, лаборатори, бие даалтын хичээлийн үр өгөөж сайн гэдэгт нийт оюутнуудын дийлэнх нь 4.0 буюу сэтгэл ханамжтай, үлдсэн 16 асуултнуудад сэтгэд ханамжийн түвшин дунд буюу >3,2 байна.

Хэлцэмж:

Бидний судалгаанд нийт оюутнуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж нь 3.22 ба үүнээс сэтгэл ханамжийн түвшин доогуур байсан үзүүлэлтүүд нь өрөө тасалгаа, анги танхим, сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал зэрэг үзүүлэлтүүд нь сэтгэл ханамжийн түвшин дунджаас доогуур буюу <2,77 байсан бол Б.Балжинням нарын 2013 онд хийсэн Анагаахын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаанд нийт оюутнуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж нь 3.03 байсан нь ойролцоо байлаа. Харин бидний судалгаанд сэтгэл ханамжийн түвшин доогуур байсан үзүүлэлтүүдэд сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага багтаж байсан бол Б.Балжинням нарын судалгаанд лекц, дадлага

семинар, лаборатори, бие даалтын хичээлийн үр өгөөж, хичээлийн хуваарийн зохицуулалт зэрэг үзүүлэлтүүд багтсанаараа ялгаатай байлаа.

Ж.Оргил нарын 2018 онд хийгдсэн Анагаахын суурь судалгааны хөтөлбөрийн үнэлгээ судалгааны үр дүнд сургалтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ нь 3.7-оос дээш байгаа нь сэтгэл ханамжийн түвшин дундажаас дээш байна гэж үзсэн бол бидний судалгаанд ерөнхий сэтгэл ханамжийн түвшин дундаж буюу 3.22 байлаа.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан оюутнуудын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд сэтгэл ханамжийн түвшин дундаж буюу 3.22 байна.
2. Өрөө тасалгаа, анги танхим, сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал зэрэг үзүүлэлтүүдэд сэтгэл ханамжийн түвшин дундажаас доогуур буюу <2,77 байна. Сэтгэл ханамжгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлсүүдэд өрөө, тасалгааны хүрэлцээ, тохижилт муу, удирдлагаас анхаардаггүй, шинэчлэл хийдэггүй, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангахгүй гэж дүгнэсэн байна. Мөн ном сурах бичгийн хүрэлцээ муу, шаардлага хангахгүй, хуучирсан, хоцрогдсон, сургалтад хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай биш, номын фонд, номын сангийн үйлчилгээ хангалтгүй, үнэ өртөг ихтэй, хуучирч хоцрогдсон зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.
3. Сувилахуйн салбараас бусад салбаруудад сургалт явагдах анги танхимийн хүрэлцээг нэмэгдүүлэх, мөн сургалтанд ашиглагдах ном, гарын авлага, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Ном зүй

1. Лхагвасүрэн Ц., Цэрэндагва Д., Дүнгэрдорж Д. “Анагаах ухааны боловсрол судлал”, УБ, 2007. х.86-87
2. Отгонбаяр Д., Цэрэндагва Д., Боловсролын стратеги. Монголын анагаах ухааны боловсролын шинэчлэл: Улаанбаатар: Мөнхийн үсэг; 2011. х. 70-82
3. John G. Dent, Ronald M. Harden, A practical guide for Medical teachers. 2006.p.19-28
4. Harden R.M. Ten questions to ask when planning a course or curriculum. 1986. Medical Education 20:356-365
5. Отгонбаяр Д. Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2010 он
6. Simpson J.G., Furnace J., Crosby J. et al. The Scottish doctor – learning outcomes for the medical undergraduate in Scotland: a foundation for competent and reflective practitioners. Medical Teacher. 2002. 24:216-143
7. Сүмбэрзул Н., Оюунбилэг Ш. Анагаах ухааны боловсрол. Улаанбаатар 2001. х.68-106.
8. Балжинням Б., Хангай Э., Булгантамир Б., Отгонбаяр Д., Амарсайхан Д. Анагаахын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. Анагаах ухааны боловсрол, УБ, 2013, №5, х. 4-7
9. Оргил Ж., Сэр-Од Х., Түвшинжаргал Ц., Оюунгоо Б. Анагаахын суурь сургалтын хөтөлбөрийн үнэлгээ. Анагаах ухааны боловсрол, УБ, 2018, №7, х.21-23

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Ц.Лхагвасүрэн*